



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2023 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2023 ОНЫ 10 ДУГААР САРЫН 25-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН
ХОРОО

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

*Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дээрх
QR кодыг уншуулан танилцах боломжтой.*

**ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН
АГУУЛГА**

2023 оны 10 дугаар сарын 25-ны өдөр, Лхагва гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	2 - 5
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	6 - 28

- 1. Монголбанкны мэдээлэл сонсох /Монголбанкны 100 жилийн ой тэмдэглэх асуудлаар/* 8 - 10
 - 2. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.09.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ/* 10 - 11
 - 3. Монгол Улсын 2024 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2023.09.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ/* 11 - 28
-

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы
Эдийн засгийн байнгын хорооны 10 дугаар сарын 25-ны өдөр
/Лхагва гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Эдийн засгийн байнгын хорооны дарга Ц.Цэрэнпунцаг ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 18 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 55.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 14 цаг 55 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Томилолттой: Ж.Бат-Эрдэнэ, Ж.Ганбаатар, Х.Ганхуяг, Т.Доржханд, Д.Өнөрболор, Т.Энхтүвшин.

Хэлэлцэх асуудлын хоёр дахь асуудал болох “Төрөөс мөнгөний бодлогын талаар 2024 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Чинзориг үг хэлж, ажлын хэсгийн ахлагч, Улсын Хурлын гишүүн Ч.Ундрам тайлбар хэлж, уг асуудлыг хойшлуулахаар тогтов.

Нэг.Монголбанкны мэдээлэл сонсох /Монголбанкны 100 жилийн ой тэмдэглэх асуудлаар/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монголбанкны Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн, Монголбанкны Дэд ерөнхийлөгч Г.Энхтайван, Монголбанкны Ерөнхий эдийн засагч Д.Ган-Очир, мөн банкны Төлбөр тооцооны газрын захирал Э.Анар, Хууль, эрх зүйн газрын захирал Д.Аюуш, Банкны бүтцийн өөрчлөлт, бодлогын газрын захирал Н.Ариунбат, Мөнгөний бодлогын газрын захирал Б.Баярдаваа, Нөөцийн удирдлага, санхүүгийн зах зээлийн газрын захирал А.Энхжин, Статистикийн газрын захирал Д.Даваасүх, Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга Б.Сүх-Очир, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, Санхүүгийн зохицуулах хорооны Үнэт цаасны газрын ахлах референт Н.Энхбаатар, Монголбанкны хэвлэл мэдээллийн ажилтан Д.Ариунаа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ц.Баянмөнх, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн референт А.Хонгорзул, мөн хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Г.Баярмаа нар байлцав.

Монголбанкны 100 жилийн ой тэмдэглэх асуудлаарх мэдээллийг Монголбанкны Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн танилцуулав.

Монголбанкны Ерөнхийлөгчийн мэдээлэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Улсын Их Хурлын гишүүд Монголбанкны 100 жилийн ойг тэмдэглэх асуудлаарх Монголбанкны Ерөнхийлөгчийн мэдээлэлтэй танилцлаа.

Мэдээлэлтэй холбогдуулан Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2.14 дэх заалт, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 113 дугаар зүйлийн 113.3 дахь хэсгийг үндэслэн “Монгол Улсад орчин цагийн банкны тогтолцоо үүсэж хөгжсөний 100 жилийн ойг тэмдэглэх арга хэмжээний тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг Байнгын хорооны дарга Ц.Цэрэнпунцаг танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Ц.Цэрэнпунцаг: “Монгол Улсад орчин цагийн банкны тогтолцоо үүсэж хөгжсөний 100 жилийн ойг тэмдэглэх арга хэмжээний тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явууля.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 4

Бүгд: 11

63.6 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 15 цаг 07 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.09.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар, Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Улсын Их Хурлын гишүүн, Эрүүл мэндийн сайд С.Чинзориг, Улсын Их Хурлын гишүүн, Барилга, хот байгуулалтын сайд Ц.Даваасүрэн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн дэд сайд М.Ганхүлэг, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Магнайсүрэн, Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Тавинбэх, Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Батболд, Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Баярбат, Санхүүгийн зохицуулах хорооны дарга Б.Баярсайхан, Үндэсний статистикийн хорооны дарга Б.Батдаваа, Монгол Улсын Ерөнхий аудитор Д.Занданбат нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ц.Баянмөнх, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн референт А.Хонгорзул, мөн хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Г.Баярмаа нар байлцав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

-Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, зарчмын зөрүүтэй санал гараагүй болно.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Өнөрболор Төсвийн байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 15 цаг 11 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Монгол Улсын 2024 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2023.09.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар, Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Улсын Их Хурлын гишүүн, Эрүүл мэндийн сайд С.Чинзориг, Улсын Их Хурлын гишүүн, Барилга, хот байгуулалтын сайд Ц.Даваасүрэн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн дэд сайд М.Ганхүлэг, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Магнайсүрэн, Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Тавинбэх, Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Батболд, Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Баярбат, Санхүүгийн зохицуулах хорооны дарга Б.Баярсайхан, Үндэсний статистикийн хорооны дарга Б.Батдаваа, Монгол Улсын Ерөнхий аудитор Д.Занданбат нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ц.Баянмөнх, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн референт А.Хонгорзул, мөн хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Г.Баярмаа нар байлцав.

Төсвийн төслийн танилцуулгыг Сангийн сайд Б.Жавхлан, төсвийн төслийн талаарх аудитын дүгнэлтийг Монгол Улсын Ерөнхий аудитор Д.Занданбат нар танилцуулав.

Танилцуулга болон аудитын дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Батгөмөр, Ш.Адъяаа нарын тавьсан асуултад Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн дэд сайд М.Ганхүлэг нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүдээс зарчмын зөрүүтэй санал гараагүй болно.

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслүүдийн хоёр дахь хэлэлцүүлгийг хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Өнөрболор Төсвийн байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 15 цаг 52 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 3 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 58 минут үргэлжилж, 18 гишүүнээс 12 гишүүн хүрэлцэн ирж, 66.7 хувийн ирцтэйгээр 15 цаг 53 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ДАРГА

Ц.ЦЭРЭНПУНЦАГ

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ
ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ
2023 оны 10 дугаар сарын 25-ны өдөр,
Лхагва гараг
Төрийн ордны “Их эзэн Чингис хаан”
танхим
14 цаг 55 минут

**БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

Ц.Цэрэнпунцаг: Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая.

Ингээд хуралдаанд оролцож байгаа гишүүдийн ирцийг танилцуулъя.

Жадамбын Бат-Эрдэнэ гишүүн гадаад томилолттой, Жамбалын Ганбаатар гишүүн гадаад томилолттой, Хассуурийн Ганхуяг гишүүн гадаадад томилолттой, Тогмидын Доржханд гишүүн лрон нутагт томилолттой, Дамдинсүрэнгийн Өнөрболор гишүүн орон нутагт томилолттой, Төмөртоогогийн Энхтүвшин гишүүн гадаад томилолттой.

Бусад гишүүд хүрэлцэн ирж, Байнгын хорооны ирц 55.6 хувьтай бүрдсэн тул Эдийн засгийн байнгын хорооны 2023 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье. /алх цохив/

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Нэг.Монголбанкны 100 жилийн ой тэмдэглэх асуудлаар мэдээлэл сонсох. Монголбанкнаас 2023 оны 9 дүгээр сарын 29-ний өдөр ирүүлсэн мэдээлэл.

Хоёр.“Төрөөс мөнгөний бодлогын талаар 2024 онд баримтлах үндсэн чиглэл

батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл. Монголбанк 2023 оны 9 сарын 25-ны өдөр ирүүлсэн. Анхны хэлэлцүүлэг.

Гурав.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл.

Засгийн газар 2023 оны 9 дүгээр сарын 29-ний өдөр өргөн мэдүүлсэн. Анхны хэлэлцүүлэг. Санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ.

Дөрөв.Монгол Улсын 2024 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төсөл.

Засгийн газар 2023 оны 9 дүгээр сарын 29-ний өдөр өргөн мэдүүлсэн. Хоёр дахь хэлэлцүүлэг. Санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ.

Тав.Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл.

Засгийн газар 2023 оны 9 сарын 29-ний өдөр Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн. Анхны хэлэлцүүлэг. Санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ.

Ирээдүйн өв сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл.

Энэ хэлэлцэх асуудлууд нийт 14 хууль. Бүгд 2023 оны 9 дүгээр сарын 29-ний өдрийн өргөн мэдүүлсэн байгаа.

Гаалийн тариф гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл, Уул уурхай бүтээгдэхүүний биржийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл, Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Төр хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, “Засгийн газарт үнэт цаас гаргах эрх олгох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл, “Засгийн газрын өрийн баталгаа гаргах зөвшөөрөл олгох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл, “Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл, “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл гэсэн 17 асуудлыг хэлэлцэнэ.

Хэлэлцэх асуудал дээр өөр саналтай гишүүд байна уу?

С.Чинзориг гишүүн асуултаа асууя.

С.Чинзориг: Мөнгөний бодлогын талаар төрөөс баримтлах бодлогын бичиг баримтын анхны хэлэлцүүлэг гээд Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал орчих шиг болох юм даа.

Уг нь Ч.Ундрам гишүүнээр ахлуулсан ажлын хэсэг ажиллаж байгаа.

Тэгээд ажлын хэсгийн хурал сая яг танхимд Ч.Ундрам гишүүн бид хоёр ирсэн. Тэгээд Б.Баттөмөр гишүүн, Т.Доржханд хоёр ирээгүй. Утсаар ярьсан. Ирцэд орьё гэж ярьсан гэсэн.

Тэгээд би ажлын хэсгийн ирцээс гарлаа гээд тэгээд 6 гишүүнтэй ажлын хэсэг гурав, гурван гишүүнтэй боллоо. Ажлын хэсэг хуралдаагүй шүү. Ирц бүрдээгүй гээд гарсан. Намайг гарахад Ч.Ундрам өөрөө ажлын хэсгийн ирц бүрдсэнгүй. Ажлын хэсгийн хурал хойшиллоо гээд хэлсэн шүү дээ. Одоо яагаад тэгээд анхны хэлэлцүүлэг гээд ороод ирж байгаа юм.

Ажлын хэсэг хуралдаагүй, ирц бүрдээгүй байхад. Ингэж болохгүй шүү дээ. Байнгын хорооны дарга.

Ц.Цэрэнпунцаг: Сая ажлын хэсгийн гишүүн С.Чинзориг сайд санал гаргалаа. Ажлын хэсгийн ахлагч Ч.Ундрам гишүүн Та тайлбараа хийх үү?

Ч.Ундрам гишүүний микрофоныг нээе.

Ч.Ундрам: Ажлын хэсэг өнөөдөр хуваарийн дагуу хуралдсан.

Тэгээд ирцэд С.Чинзориг гишүүн байж байгаад ирцээс гарсан. Тэгээд хуралдах боломжгүй болоод бид ажлын хэсгээ хуралдуулж чадаагүй.

Тийм учраас ямар нэгэн санал хураалт хийгдээгүй. Тийм. Тэгээд яах вэ бид нар бас нэг хугацаатай. Хугацаа нь арай болоогүй байгаа. Энэ мөнгөний бодлогыг батлах. Тийм

Тэгэхээр хойшлуулж болох байх гэж бодож байна. Тийм.

Ц.Цэрэнпунцаг: Сая ажлын хэсгийн ахлагч дахиад хуралдахад цаг хугацаагаар хавчигдсан асуудал байхгүй. Боломжтой гэж үзэж тайлбарлаж байгаа учраас өнөөдрийн Эдийн засгийн байнгын хорооны хуралдааны хэлэлцэх асуудлаас “Төрөөс мөнгөний бодлогын талаар 2024 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын

тогтоолын төслийн хэлэлцэхийг хасчихъя.

Ингээд бусад 16 асуудлыг хэлэлцье.

Өөр саналтай гишүүд байхгүй байгаа тул хэлэлцэх асуудалдаа оръё.

Хэлэлцэх асуудал нэг.

Нэг.Монголбанкны мэдээлэл сонсох

/Монголбанкны 100 жилийн ой тэмдэглэх асуудлаар/

Монголбанкны 100 жилийн ой тэмдэглэх асуудлаар мэдээлэл сонсож эхэлье.

Мэдээллийг Монголбанкны Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн танилцуулна.

Б.Лхагвасүрэн Ерөнхийлөгчийн микрофон нээе. Ажлын хэсгийн 3 номер.

Б.Лхагвасүрэн: Та бүхний энэ өдрийн амар амгаланг эрж мэндчилье.

2024 оны 6 сарын 02-нд Монголбанк байгуулагдсаны 100 жилийн ой тохиож байгаа.

Монгол, Зөвлөлтийн хувь нийлүүлсэн Худалдаа, аж үйлдвэрийн банк 1924 оны 6 сарын 02-ны өдөр албан ёсоор байгуулагдсан бөгөөд энэ цагаас хойш 100 гаруй жилийн хугацаанд банк, санхүүгийн салбарын хөгжлийг түүчээлж, Монгол Улсын мөнгөний бодлогыг Монголбанк тодорхойлж ирсэн.

Энэхүү түүхэн ойг Төв банканд итгэх иргэд, олон нийтийн итгэлийг нэмэгдүүлэх, банк, санхүүгийн салбарын үйлчилгээг ойртуулах, хүртээмжийг нэмэгдүүлэх, тус салбарын цаашдын хөгжлийг оновчтой тодорхойлох хүрээнд тэмдэглэе гэсэн саналыг Монголбанкнаас гаргасан.

Гол нь банк, санхүүгийн системийн ололт амжилтыг олон нийтэд мэдээлж сурталчлах, түгээн дэлгэрүүлэх, туршлага солилцох, оюун ухаан сорих зэрэг мэдлэг шалгасан олон нийтийн дунд уралдаан зохион байгуулах.

Үүнээс гадна ерөнхийдөө олон улсын нэлээн томоохон байгууллагуудыг урьж авчраад банк, санхүүгийн системийн хөгжил, онцлог, мөн орчин үеийн мөнгөний бодлого, Төв банкнуудын барьж байгаа зарчим, байр суурьтай холбоотойгоор нэлээн өндөр түвшний онол, практикийн бага хурлыг зохион байгуулья гэж төлөвлөж байгаа.

Энэ үүднээсээ 100 жилийн арга хэмжээг ерөнхийдөө олон нийтэд

чиглэсэн хэлбэрээр зохион байгуулья гэсэн саналыг Эдийн засгийн байнгын хороондоо хүргүүлсэн юм.

Ц.Цэрэнпунцаг: Мэдээлэлтэй холбогдуулан асуулт асууж, үг хэлэх гишүүд байна уу? Алга байна.

Гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа.

Тийм. 100 жилийн ойд тэмдэглэх тогтоол гаргана шүү дээ. Байнгын хорооны тогтоол гаргана.

Мэдээлэлтэй холбогдуулж Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 113 дугаар зүйлийн 113.3 дахь хэсгийг үндэслэн Байнгын хорооны тогтоолын төсөл боловсруулсан байгаа.

Тогтоолын төслийг Та бүхэндээ уншиж танилцуулья.

Монгол Улсад орчин цагийн банкны тогтолцоо үүсэж хөгжсөний 100 жилийн ойг тэмдэглэх арга хэмжээний тухай.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2.14 дэх заалт, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 113 дугаар зүйлийн 113.3 дахь хэсгийг үндэслэн Эдийн засгийн байнгын хорооноос ТОГТООХ нь:

1.Монгол Улсад орчин цагийн банкны тогтолцоо үүсэж хөгжсөний 100 жилийн ойг тохиолдуулан Монгол Улсын банк, санхүүгийн системийн хөгжил, Төв банкны үйл ажиллагааны ач холбогдлыг иргэд, олон нийтэд сурталчлан таниулах зорилгоор дараах арга хэмжээг зохион байгуулсугай.

- 1) Монгол Улсын Үндсэн хууль болон Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн шинэчлэлийн үзэл баримтлал, дэлхийн эдийн засгийн хөгжлийн түгээмэл хандлага, Монгол Улсын банк, санхүүгийн системийн хөгжил, онцлогт нийцүүлэн тус салбарын цаашдын хандлага, Төв банкны бие даасан хараат бус байдлыг бэхжүүлэх хүрээнд онол, практикийн бага хурал зохион байгуулах;
- 2) банк, санхүүгийн системийн ололт амжилтыг олон нийтэд мэдээлэл сурталчлах, түгээн дэлгэрүүлэх, туршлага солилцох, оюун ухаан сорих тэмцээн, өдөрлөг, ажил, мэргэжлийн уралдаан зохиох;
- 3) иргэд, олон нийтэд чиглэсэн үйлчилгээ үзүүлэх, тэдний санал, хүсэлтийг сонсох, бүтээлч ажил, үйл ажиллагаанд оролцуулах;
- 4) банк, санхүүгийн салбарын ажилтнуудын хөдөлмөр, бүтээлийг тодруулан алдаршуулах, тэмдэглэх, шагнаж урамшуулах;
- 5) түүхт ойг тэмдэглэн өнгөрүүлэхэд шаардлагатай бусад арга хэмжээ.

2.Энэ тогтоолын 1 дэх хэсэгт заасан арга хэмжээг зохих байгууллагуудтай хамтран зохион байгуулж, зардал гаргахыг Монголбанк /Б.Лхагвасүрэн/-нд даалгасугай.

Тогтоолын төслийг Та бүхэндээ танилцууллаа.

Энэ дээр өөр саналтай гишүүд байна уу? Алга байна.

Санал хураалт явуулж эхэлье.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 113 дугаар зүйлийн 113.3 дахь хэсгийг үндэслэн Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

Гишүүдийн 63.6 хувь нь дэмжиж санал дэмжигдлээ.

Санал хураалт явуулж дууслаа. Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Монголбанкны 100 жилийн ойг тэмдэглэх асуудлаарх Монголбанкны мэдээлэлтэй танилцаж дууслаа.

Дараагийнхаа асуудалд орёе.

Хэлэлцэх асуудал хоёр. Уучлаарай. Хоёр дахь асуудлыг бид өнөөдрийн асуудлаас хойшлуулсан учраас хэлэлцэх асуудал гурав руу орёе.

Хоёр. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

/Засгийн газар 2023.09.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ/

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулъя.

Ажлын хэсгийн гишүүдийн нэрсийг танилцуулъя.

Ч.Хүрэлбаатар Эдийн засаг, хөгжлийн сайд, С.Чинзориг Эрүүл мэндийн сайд, Ц.Даваасүрэн Барилга, хот байгуулалтын сайд, Б.Жавхлан Сангийн сайд,

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас М.Ганхүлэг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн дэд сайд,

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамнаас С.Магнайсүрэн Уул уурхай, хүнд

үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга,

Эрчим хүчний яамнаас Н.Тавинбэх Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга,

Зам, тээврийн хөгжлийн яамнаас С.Батболд Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга,

Барилга, хот байгуулалтын яамнаас Ц.Баярбат Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч,

Санхүүгийн зохицуулах хорооноос Б.Баярсайхан Санхүүгийн зохицуулах хорооны дарга,

Үндэсний статистикийн хорооноос Б.Батдаваа Үндэсний статистикийн хорооны дарга,

Үндэсний Аудитын газраас Д.Занданбат Монгол Улсын ерөнхий аудитор болон бусад албаны хүмүүс оролцож байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-д заасны дагуу Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэнэ.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Алга байна.

Төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай. Энэ дээр алга байна. Тийм үү. Энэ дээр зарчмын зөрүүтэй санал ирээгүй байна.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа. /алх цохив/

Төсвийн байнгын хороонд хүргүүлэх санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Төсвийн байнгын хорооны гишүүн Д.Өнөрболор Төсвийн байнгын хороонд уншиж танилцуулна.

Дараагийн асуудалдаа орёё.

**Гурав.Монгол Улсын 2024 оны төсвийн тухай,
Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай,
Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслүүд**
*/Засгийн газар 2023.09.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг,
санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ/*

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлье.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулчихсан.

Монгол Улсын 2024 оны төсвийн төслийн талаарх танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Болдын Жавхлан танилцуулна.

Б.Жавхлан сайдын микрофоныг нээе.

Б.Жавхлан: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас Монгол Улсын 2024 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслийг 2023 оны 9 дүгээр сарын 29-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн.

Засгийн газраас эдийн засгийн өсөлтийг эрчимжүүлж, экспортыг

нэмэгдүүлэх, үнийн өсөлтийг хязгаарлаж, иргэдийн бодит орлогыг хамгаалахад чиглэсэн бодлого, арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлж байна.

Засгийн газраас авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнд улсын эдийн засаг сайжирч, улмаар урт хугацааны хөгжлийн эхний 10 жилийн зорилт болох **“Шинэ сэргэлтийн бодлого”** хэрэгжүүлэх боломж бүрдээд байна.

Тиймээс “Шинэ сэргэлтийн бодлого”-ын гол зорилтын нэг болох “Хот, хөдөөгийн сэргэлт”-ийг дэмжихэд чиглэсэн төсөв, санхүүгийн багц арга хэмжээг хэрэгжүүлэхээр ирэх 2024 оны төсвийн төсөлд тусгасан болно.

Ирэх 2024 онд эдийн засгийн бодлогын чиглэлээр хэрэгжүүлэх зарим онцлог арга хэмжээг дурдвал:

Нэг. “Шинэ сэргэлтийн бодлого”-ын “Хот, хөдөөгийн сэргэлт”-ийн хүрээнд хөдөө орон нутгийг орон сууцжуулах, далд эдийн засгийг бууруулах, хөдөөгийн хөгжлийг түргэтгэхэд чиглэсэн багц арга хэмжээ хэрэгжүүлэх.

Хоёр. Татвар нэмэхгүйгээр бизнесийн орчин, хөрөнгө оруулалт, хөрөнгийн зах зээл, боловсруулах үйлдвэрийг дэмжсэн төсвийн орлогын суурийг өргөжүүлэх татварын бодлого хэрэгжүүлэх.

Гурав. Төсвийн хөрөнгө оруулалтыг нийгмийн ач холбогдол, эдийн засгийн үр ашигтай төслүүдэд хуваарилах, гадаад зээл, тусламжийг усан цахилгаан станц, газрын тосны үйлдвэр зэрэг тэргүүлэх ач холбогдол бүхий бүтээн байгуулалтын томоохон төслүүдийг санхүүжүүлэхэд ашиглах.

Дөрөв. Цалин, тэтгэврийг эдийн засгийн өсөлт, инфляц, амьжиргааны түвшинтэй уялдуулан индексжүүлэх.

Тав. Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станцын усан сан бүрдүүлэх талбайд оршин суугаа иргэдийг нүүлгэн шилжүүлсний нөхөн олговрыг бүрэн олгож дуусгах.

Монгол Улс эрдэс, түүхий эдийн зах зээлд нэвтрэх хэрэгцээ шаардлага, түүнчлэн хөдөө аж ахуй, аялал жуулчлал, гамшгийн эрсдэлийн удирдлагыг сайжруулах зорилгоор Монгол орны өмнөд хэсгийн 255 мянган километ квадрат талбайг хамруулан геологи, хайгуулын судалгаа хийх.

“Боомтын сэргэлт”-ийн хүрээнд хилийн боомтуудын нэвтрэх хүчин чадлыг нэмэгдүүлэхтэй холбогдуулан Дэглий цагаан, Цагаан дэл-Уул, Бичигт, Боршоо, Бургастай, Алтанбулаг, Замын-Үүд, Шивээхүрэн, Гашуунсухайт зэрэг боомтуудад шаардлагатай орон тоо, бусад урсгал зардлыг шийдвэрлэх.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан **“Хүнсний хангамж, аюулгүй байдал”** хүнсний хөдөлгөөний хэрэгжилтийг эрчимжүүлж, хүнсний ногоо, газар тариалангийн ажлын явц бүсийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг технологийн парк, мах, ноос, арьс шир, түүхий эд, хүнс, сүү боловсруулах үйлдвэрүүдийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих зээлийн хүүгийн татаас, мөн **“Тэрбум мод”** үндэсний хөдөлгөөнийг дэмжиж, ойжуулалтын арга хэмжээний урсгал зардлыг санхүүжүүлэх зэрэг арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөөд байна.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Ирэх 2024 оны төсөв, санхүүгийн бодлогыг хэрэгжүүлснээр эдийн засгийн өсөлт **7** хувьд хүрч, Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого **25.3** их наяд төгрөг, нэгдсэн төсвийн нийт зарлага **27.4** их наяд төгрөг, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлснээс алдагдах **2.1** их наяд төгрөг буюу дотоодын нийт бүтээгдэхүүний **2.8** хувь болж төсвийн тусгай шаардлага хангагдаж байгаа болно.

Иймд ирэх оны төсвийн төсөлд эдийн засгийн бодлогын чиглэлээр тусгасан арга хэмжээнүүдтэй танилцаж, Монгол Улсын 2024 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслийг хэлэлцэн шийдэж өгөхийг хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Ц.Цэрэнпунцаг: Б.Жавхлан сайдад баярлалаа.

Монгол Улсын 2024 оны төсвийн төсөлд хийсэн аудитын дүгнэлтийн талаарх танилцуулгыг Монгол Улсын ерөнхий аудитор Доржсүрэнгийн Занданбат танилцуулна.

Ажлын хэсгийн 3 номерын микрофоныг нээе.

Д.Занданбат: Эдийн засгийн байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Төрийн аудитын байгууллагаас Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.7 болон Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд 22 дугаар зүйлийн 22.3 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын 2024

оны нэгдсэн төсвийн төсөлд дүгнэлт өгөх аудитыг гүйцэтгэлээ.

Монгол Улсын Засгийн газраас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2024 оны төсвийн төслийг арвилан хэмнэлттэй, үр ашигтай, үр нөлөөтэйгөөр боловсруулж, төрийн санхүүгийн удирдлагыг сайжруулан, эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангахад чиглэсэн эсэхийг **7** зорилтын хүрээнд хянаж үнэлэхэд аудитын зорилго чиглэсэн.

Төрийн аудитын байгууллага нь Монгол Улсын 2024 оны төсвийн төслийг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 22 дугаар зүйлд заасан дараах шаардлагад нийцсэн гэж дүгнэж байна.

1.Засгийн газраас өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2024 оны төсвийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хуулийн 25 дугаар зүйлийн 1.7 дахь хэсэгт заасны дагуу улсын хөгжлийн бодлоготой нийцэж байна.

Засгийн газрын өрийн үлдэгдэл дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх харьцаа 2024 онд 40.7 хувьд хүрэх төсөөлөлтэй байхаар тооцоолон тусгасан нь Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.2.3-д заасан төсөв, санхүүгийн аюулгүй байдлын бодлогын зохистой харьцаанд байна.

2.Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн төсөлд төсвийн тэнцвэржүүлсэн орлого 25 их наяд 289.8 тэрбум төгрөг буюу дотоодын нийт бүтээгдэхүүний 34.2 хувь, нийт зарлага 27 их наяд 360.5 тэрбум төгрөг буюу дотоодын нийт бүтээгдэхүүний 37 хувь, тэнцвэржүүлсэн тэнцэл 2 их наяд 70.8 тэрбум төгрөгийн алдагдалтай буюу дотоодын нийт

бүтээгдэхүүний 2.8 хувьтай тэнцэж байхаар төлөвлөжээ.

3.Монгол Улсын 2024 оны төсвийн төслийг боловсруулахад Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнд тусгагдсан дараах зорилт, хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Үүнд:

- “Шинэ сэргэлтийн бодлого”-д тусгасан хот, хөдөөгийн тэнцвэртэй хөгжлийг хангах, орон нутгийн иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлэх;
- хилийн боомтын нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлж, экспортыг дэмжих;
- уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжааг эрчимжүүлэх;
- Иргэдийн орлогыг хамгаалж, цалин, тэтгэвэр, тэтгэмжийг үнийн өсөлттэй уялдуулан нэмэгдүүлэх;
- хөгжилд суурилсан хөрөнгө оруулалтыг эрчимжүүлэх;
- эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, иргэд эх орондоо оношлогдон эмчлүүлэх боломжийг нэмэгдүүлэх;
- уул уурхайн орлогоос орон нутгийн хөгжлийн санд нэмэлт орлого хуваарилах, иргэдийн ая тухтай амьдрах орчныг сайжруулах, тогтвортой хариуцлагатай уул

уурхайг дэмжиж байгалийн баялгийн үр өгөөжийг орон нутгийн хөгжилд чиглүүлэх;

Засгийн газраас өргөн мэдүүлсэн 2024 оны төсвийн төсөлд тус Байнгын хороонд хамаарах төсвийн ерөнхийлөн захирагчдын төсвийг дараах байдлаар төлөвлөжээ.

Санхүүгийн зохицуулах хорооны дарга:

-Төвлөрүүлэх орлого **2.7** тэрбум, зардал **15** тэрбум.

Үндэсний статистикийн хорооны дарга:

-Орлого байхгүй. **21.6** тэрбум төгрөгийн зардал.

Барилга, хот байгуулалтын сайд:

-**413.6** тэрбум төгрөгийн зардал.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд:

-Төвлөрүүлэх орлого **426.2** тэрбум, зардал **60.2** тэрбум.

Зам тээврийн хөгжлийн сайд:

-**175.3** тэрбум төгрөгийн төсвийн орлого төвлөрүүлэх, **682.2** тэрбум төгрөгийн зардал.

Эрчим хүчний сайд:

-Орлогогүй. Зардал **359.8** тэрбум төгрөг.

Тус Байнгын хороонд харьяалагдах Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын төсөвт төвлөрүүлэх орлогын дүн **62.2** тэрбум төгрөгөөр буурсан нь газрын тосны орлогоос шалтгаалсан байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчдын нийт зарлага ба зээлийн дүнг 2023 оны тодотгосон төсвөөс **352.0 тэрбум** төгрөгөөр нэмж, **1 их наяд 552.5 тэрбум** төгрөгөөр төлөвлөсөн нь дотоодын агаарын тээвэрлэгчдийг дэмжих зээлийн хүүгийн татаас олгох, Засгийн газраас 2024 онд нийт албан хаагчдын үндсэн цалинг 10 хувиар нэмэгдүүлэх бодлого баримталсантай холбоотой байна.

Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2024 онд хэрэгжүүлэх хөтөлбөр нь “**Алсын хараа-2050**” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны зорилго, зорилттой нийцэж буй хэдий ч Монгол Улсын 2024 оны хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээнээс:

- Санхүүгийн зохицуулах хороо **2**,
- Барилга, хот байгуулалтын яам **4**,
- Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам **11**,
- Зам тээврийн хөгжлийн яам **5**,
- Эрчим хүчний яам **4**.

Нийт **26** хөтөлбөр, арга хэмжээг тусгаагүй байна. Үүнд:

Санхүүгийн зохицуулах хороо:

- Хөрөнгийн зах зээлийн зохицуулалтыг оновчтой болгож, биржийн үйл ажиллагааг өргөжүүлж тогтворжуулах;
- Зах зээлд оролцогчдын эрх ашгийг бүрэн хангах, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог боловсронгуй болгох.

Барилга, хот байгуулалтын яам:

- -Бүгд Найрамдах Польш Улсын зээлээр 5 аймгийн төвд бохир ус цэвэрлэх байгууламж барих төслийг үргэлжлүүлэх;
- Баян-Өлгий, Дорнод, Говьсүмбэр, Завхан, Увс, Улаанбаатар хотын гэр хорооллын 55 мянган өрхийг инженерийн дэд бүтцээр хангах төсөл хэрэгжүүлэх;
- Газар зүйн мэдээллийн системд суурилсан газар, үл хөдлөх хөрөнгийн бүртгэл, үнэлгээ, татвар, төлбөрийн нэгдсэн системийг хөгжүүлэх;
- Газрын тохиромжтой болон хэрэгцээт үнэлгээ, газар зохион байгуулалтын төлөвлөлт, хяналтын системийг хөгжүүлж хэрэглээнд нэвтрүүлэх.

Уул уурхайн хүнд үйлдвэрийн яам:

- Орчин үеийн дэвшилтэт технологи ашиглан агаарын геофизикийн цогц судалгааны ажлыг гүйцэтгэх;
- Газрын ховор элемент болон өндөр технологийн түүхий эдийн хэтийн төлөвийн судалгаа хийх;
- Цагаан суваргын зэс, молибдены ордыг ашиглалтад оруулах;
- Хармагтайн зэс, алтны болон Асгатын мөнгөний ордыг ашиглалтад оруулах бэлтгэл ажил хангах;
- Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр байгуулах;

- Дорноговь аймгийн Хөвсгөл сумын “Гэрэлт говь” кокс, металлургийн үйлдвэр, үйлдвэрлэл-технологийн парк байгуулах;
- “Эрдэнэс Тавантолго” хувьцаат компанийн нүүрс баяжуулах үйлдвэр байгуулах ажлыг үргэлжлүүлэх;
- Гангийн үйлдвэр байгуулах;
- Газрын тос дамжуулах хоолой барих төслийг хэрэгжүүлэх;
- Эрдэнэт үйлдвэр төрийн өмчит үйлдвэрийн газар түшиглэн уул уурхайн металлург, химийн үйлдвэрийн цогцолбор үйлдвэр-технологийн паркийн дэд бүтцийг байгуулах;
- Дорноговь аймагт Алтанширээд аж үйлдвэрийн парк байгуулах.

Зам тээврийн хөгжлийн яам:

- Ховд, Улаангом чиглэлийн 163.0 километр авто зам барих;
- Улиастай, Алтай чиглэлийн 42.0 километр авто зам барих;
- Хил орчмын болон хил дамнасан аялал жуулчлалын бүс нутгуудын хамтын ажиллагааг өргөжүүлж, жуулчид автомашинтайгаа аялах боломжийг бүрдүүлж, олон улс, улс хооронд орон нутгийн авто замын дагуу 100-аас 200 километр

тутамд үйлчилгээний цогцолбор, амрах талбай байгуулах;

- Эрдэнэт чиглэлийн Төв аймгийн Жаргалант сумын Жаргалантын уулзвараас эхлэлтэй Сэлэнгэ аймгийн Орхон сумын А1001 авто замын Орхон сумын уулзварт төгсөх хатуу хучилттай 100.0 километр авто зам барих;
- Богд хаан төмөр зам төслийг эхлүүлэх;

Эрчим хүчний яам:

- Тавантолгой 300 нэмэх 150 мегаваттын цахилгаан станц холбогдох дэд станцын бүтээн байгуулалтыг эхлүүлэх;
- Дулааны III цахилгаан станцыг өргөтгөх;
- Багахангайн 300 мегаваттын дулааны цахилгаан станцын төслийг үргэлжлүүлэх;
- Хөшгийн хөндийн шинэ хотын инженерийн дэд бүтэц төслийг үргэлжлүүлэх зэрэг болно.

Тус Байнгын хороонд харьяалагдах төсвийн ерөнхийлөн захирагчдын 2024 оны төсвийн багцад нийт **1 их наяд 226.4 тэрбум** төгрөгийн **258 төсөл, арга хэмжээг** санхүүжүүлэхээр төлөвлөснөөс хөгжлийн жилийн төлөвлөгөөнд **407.1 тэрбум** төгрөгийн **125 төсөл, арга хэмжээ** тусгагдсан.

819.3 тэрбум төгрөгийн **133 төсөл, арга хэмжээ** тусгагдаагүй байна.

Үр дүнд чиглэсэн төсөвлөлтийн аргыг улсын болон орон нутаг, мөн салбарын төсөвлөлтөд хэрэгжүүлснээс бий болох үр өгөөж, ач холбогдлыг нэмэгдүүлэх зорилгоор хэмжих үзүүлэлтийг тодорхой болгож, хүрэх үр дүнг богино, дунд хугацаагаар тодорхойлж үйл ажиллагааг хэмжсэнээр төсвийн зардлын ашиглалт, үр өгөөж нэмэгдэж, төсөвлөсөн хөтөлбөр бүрэн хэрэгжүүлэх боломжтой болно.

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.7-д заасны дагуу Монгол Улсын 2024 оны төсвийн төсөлд хийсэн аудитын дараах дүгнэлтийг танилцуулъя.

Нэг.Төсвийн төсөлд макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд, эрдэс баялгийн бүтээгдэхүүний экспортын хэмжээ, татварын орлого зэргийг өөдрөгөөр төсөөлсөн нь төсвийн гүйцэтгэлд эрсдэл үүсвэл төсөвт тодотгол хийх нөхцөлд хүргэж болзошгүй байна.

Хоёр.Төсвийн ерөнхийлөн захирагч нар төсвийн төслийг боловсруулахдаа хөтөлбөр бүрийн өртгийг тооцоогүй, арга хэмжээний хүрэх түвшин, шалгуур үзүүлэлтийг тоон болон чанарын утгаар хэмжигдэхүйцээр бодитой тодорхойлолгүйгээс төсвийн зорилго хангагдах эсэхийг үнэлэх боломжгүй байна.

Гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хийгдэх төсөл, арга хэмжээний саналыг эрэмбэлэх, эдийн засаг, нийгмийн ач холбогдол, урт болон дунд хугацааны бодлогын баримт бичигтэй уялдуулан эдийн засгийн бодит үр өгөөжийн тооцоо, судалгаа хийх аргачлалыг боловсруулан баталж Өрийн удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх заалтыг хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Гадаад өрийн төсөвт үзүүлэх ачааллыг бууруулах зорилгоор дотоод үнэт цаас гарган төсвийн алдагдлын тодорхой эх үүсвэрийг бүрдүүлэхээр төсвийн төслийг боловсруулсан боловч түүний үр ашгийг нарийвчлан тооцоолоогүй байна.

Барилга байгууламжид зураг төсөл, магадлал хийх, худалдан авах ажиллагаа зохион байгуулах, гэрээ байгуулах, захиалагчийн хяналт болон гэрээний хэрэгжилтийг хангуулах, улсын комисс, барилга байгууламжийг хүлээн авах зэрэг төсвийн хөрөнгө оруулалтын үйл явцад тавих дотоод хяналтын тогтолцоог сайжруулан субъектив сөрөг нөлөөллийг бууруулах эрх зүйн тодорхой нарийвчилсан зохицуулалтыг бий болгох шаардлагатай байна.

Монгол Улсын Засгийн газар дараа оны төсвийн төслийг боловсруулж Улсын Их Хуралд өргөн барихдаа төрийн аудитын байгууллагаас өгч буй дараах зөвлөмжүүдийг хэрэгжүүлж ажиллах шаардлагатай байна.

Монгол Улсын төсвийн төслийг Улсын Их Хуралд өргөн барихдаа төсвийн төсөл боловсруулах тухайн үед хүчин төгөлдөр мөрдөгдөж буй төсвийн хүрээний мэдэгдэлд үндэслэсэн байх.

Төсвийн төлөвлөлтийн дунд ба урт хугацааны төлөвлөлтийг төсвийн алдагдлыг 2 хувиас бага байлгах, эдийн засгийн зохистой харьцааг баримтлан төсвийн тогтвортой байдлын үндсэн зарчмыг хангаж төсөвт үзүүлэх гадаад өрийн ачааллыг бууруулж төлөвлөлтийг сайжруулах.

Улсын хөгжлийн бодлогын баримт бичигтэй нийцсэн зөвхөн төсөвлөлтийн шаардлага хангасан төсөл, арга хэмжээг төсвийн төсөлд тусгаж байх.

Улсын төсвөөс санхүүжүүлж хэрэгжүүлэхээр төсвийн хуульд тусгаж баталсан төсөл, арга хэмжээний төсөвт өртгийн дүнд өөрчлөлт орж буй шалтгаан нөхцөлд нарийвчилсан судалгаа, дүн шинжилгээ хийж холбогдох арга хэмжээг авч ажиллах.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.4-д заасны дагуу хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ төлөвлөсөн хугацаанд бүрэн хэрэгжих боломжгүй нөхцөл үүссэн тохиолдолд гэрээ байгуулах шийдвэр гаргахгүй байх чиглэлийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт өгч хэрэгжилтэд нь хяналт тавих.

Төсвийн төслийг тогтвортой хөгжлийн бодлогод нийцсэн эсэх хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлж, хөгжлийн бодлого төлөвлөлтийн үйл ажиллагааг улс орон нутгийн хэмжээнд үр дүнтэй хэрэгжүүлж, удирдан зохион байгуулах.

Гадаадын зээлийн хөрөнгөөр шинээр хэрэгжүүлэх хэлэлцээрт орж буй төсөл, арга хэмжээнд эдийн засгийн үр ашгийн тооцоог хийж, ач холбогдлоор нь эрэмбэлж, санхүүжүүлэх журам, арга аргачлалыг боловсруулж хуулийн хэрэгжилтийг хангах.

Хөгжлийн бодлогод нийцүүлсэн үр дүнд суурилсан төсвийн төлөвлөлтийг бүрэн хэрэгжүүлж, салбарын бодлого, төлөвлөлт хариуцсан албан хаагчдыг нэгдсэн арга зүйгээр хангаж чадавхыг нь сайжруулах зэрэг болно.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Ц.Цэрэнпунцаг: Д.Занданбат даргад баярлалаа.

Монгол Улсын 2024 оны төсвийн төслийн болон Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах төсвийн ерөнхийлөн захирагчдын төсвийн талаарх товч танилцуулгыг Улсын Их Хурлын Тамгын газрын Төсвийн хяналт шинжилгээний хэлтсээс бэлтгэн ирүүлснийг Та бүхэнд хүргүүлсэн болно.

Хууль санаачлагчаас болон Байнгын хорооны өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хамаарах төсвийн ерөнхийлөн захирагчдаас асуух асуулттай гишүүд нэрсээ өгнө үү?

Ш.Адъяаа гишүүнээр тасаллаа. Ингээд Б.Баттөмөр гишүүн асуултаа асууя.

Б.Баттөмөр: Монгол Улсын 2024 оны төсвийн орлого 27 их наяд нэгдсэн төсвийн орлого, тэнцвэржүүлсэн тэнцэл нь 25 их наяд болж байна.

Үүнийхээ наян хэдэн хувийг нь урсгал зардал гээд явчихна. Хөрөнгө оруулалт 5 хувь нь байгаа юм байна. Дотоодын нийт бүтээгдэхүүний.

Хөрөнгө оруулалтын энэ задаргааг үзэж байхад сонин сонин юм явцгааж л байна л даа.

Бяслагийн үйлдвэр байгуулна ч гэх шиг. Ашигт малтмалдаа өөрийн бодлогоо явуулж чадахгүй бяслагийн үйлдвэрт хөрөнгө оруулдаг гэж юм байдаг юм уу? Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, суманд очоод ноос хяргах тоног төхөөрөмж байршуулна ч гэх шиг.

Энэ чинь одоо малаа бүгдийг нь хувьчилчихсан. Хөнгөн үйлдвэрийнхээ ноосны үйлдвэрийг бүгдийг нь хувьчлаад хаячихсан шүү дээ. Сумд очиж тийм юм

байгуулаад байх юмгүй. Гэх мэтийн юмнууд байх юм.

Тэгээд “Алсын хараа-2050” хөгжлийн баримт бичгүүдтэйгээ нийцэж байгаа юм уу? Нэгдүгээр асуулт.

Хоёрдугаарт нь, Сангийн сайдын 7 заалт гээд хөрөнгө оруулалтыг эрэмбэлдэг нэг тийм юм байдаг. Тэр энэ тэрээр орж шалгагдсан юм уу? Энд хариулт авъя.

Дараагийн асуудал яах вэ, манай нийт эдийн засгийн хэмжээ 74 их наяд төгрөг болж байгаа юм.

Эндээс тэр 27 нь төсвийн орлого. 27 их наяд гэж үзэхээр дотоодын нийт бүтээгдэхүүнд оногдох тэр орлогын хэмжээ 36.4 хувь болоод ер нь их боломжийн хэмжээнд оччихсон байгаа.

Тэгээд эндээс юу харагдаж байна гэхээр зэрэг бид татвар нэмэх арга ерөөсөө алга. Тэр далд эдийн засгийг ил болгох, эдийн засгаа тэлэх арга хэмжээ авч байж төсвийн орлогыг нэмэгдүүлэх ийм л шаардлага тулгарч байгаа юм.

Төсвийн орлогын чинь тэр нөгөө хоёр сангийнхыг хасаад 25 их наяд төгрөгийн одоо хэд нь тэр далд эдийн засаг. Сая Сангийн сайдын илтгэлд далд эдийн засгийг ил болгох арга хэмжээ авна гээд гарчихлаа.

Энэ 27 их наяд төгрөгөөс далд эдийн засгийг ил болгох чиглэлд хэдэн төгрөг явж байна гэсэн нэг дэх асуулт байгаа юм.

Хоёрдугаарт, энэ инфляц 8.5 гэж байгаа.

Монголбанк хэлэхдээ инфляц их өндөр гарна гэж байгаа юм. 23 их наяд

төгрөгөөс дээш гарсан 1 их наяд төгрөг тутамд 1 хувийн инфляц дагалдана гэж байгаа юм.

Ингээд үзэхээр манай инфляц 12, 13 болоод байгаа юм. Мөнгөний бодлоготойгоо хэр зэрэг уялдуулж тооцож байгаа вэ гэсэн нэг ийм асуулт байгаа юм.

Дараагийн асуудал бол ядуурал.

Монгол Улс ядуурлын хавханд орчихсон байгаа шүү дээ. Бид нарыг чинь их мундаг ардчилсан улс, ардчиллын бэлгэ тэмдэг, гэрэлт цэг л гээд байдаг.

Яг үнэндээ нийт хүн амын 28 хувь нь ядуурчихсан. Дээрээс нь 15 хувь нь ядуурах магадлалтай. 42, 43 хувь нь ядуурах магадлалтай болчихсон.

Тэгээд ядуурлыг бууруулах чиглэлд ямар арга хэмжээ авч байх вэ?

Энэ төсвийн орлого, энэ зардалд ядуурлыг бууруулах чиглэлд юу төлөвлөж байна? Энэ тоо хэмжээг яаж багасгах юм бэ гэсэн ийм асуулт байгаа юм.

Эдийн засгийн өсөлт 7 хувь. Эдийн засгийн өсөлтийн 7 хувийн хэдэн хувь нь бүтээмжид суурилж байна аа? Бүтээмж гэдэг юм маш чухал. Тийм ээ. Цалин хөлс 10 хувиар нэмэх юм байна. Бүтээмж нэмж байж болно шүү дээ.

Тэгэхээр бүтээмж яаж нэмэгдэх юм?

Ц.Цэрэнпунцаг: Б.Баттөмөр гишүүний асуултад хариулах уу? 4 асуулт асуулаа. Ч.Хүрэлбаатар сайд хариулъя.

Ч.Хүрэлбаатар: Б.Баттөмөр гишүүний хэд хэдэн асуултад хариулъя.

Эдийн засгийн бодлоготой холбоотой зүйлүүд дээр хариулъя.

Эдийн засгийнхаа өсөлтийг 7 хувиар авсан. Энэ дээр би юуны өмнө Эдийн засгийн байнгын хорооны их олон гишүүддээ талархал илэрхийлэх ёстой.

Яагаад гэвэл уул уурхайн биржийн тухай, бүтээгдэхүүнийг биржээр зарж борлуулах хуулийг баталсан.

Энэ бол уул уурхайн салбарт ил тод байдлыг авчирч, элдэв бусын хулгай хээл хахуулийг хумихад чухал үүрэг гүйцэтгэж байгаа хууль.

Үүнийгээ дагаад юм нь ил тод болоод эхлэхээр, түрүүн Б.Баттөмөр гишүүний хэлээд байгаа далд эдийн засгийн зүйлүүд ил болж эхэлж байгаа.

Монгол Улсынхаа хамгийн том салбар дээр хулгай, элдэв бусын хууль бус үйл ажиллагаануудыг алга болгосноороо бид бүх зүйлийг ил болгосон. Ийм учраас Эдийн засгийн байнгын хороон дээрээс уул уурхайн бүтээгдэхүүнийг биржээр зарж борлуулах хуулийг яг ном журмаар нь нэлээн хатуу шаардлагатайгаар баталсан нь далд эдийн засгийг ил болгоход их чухал болгож байгаа.

Дараагийн нэг зүйл. Энэ далд эдийн засгийг ил болгоход болохгүй, болохгүй гэдэг энэ зүйлүүдийг бид нар авч хаяж байгаа. Тухайлбал, арьс ширээ гаргахгүй гээд 2014 онд батлаад хаячихсан. Тэрийгээ аваад хийчих гэхээр тэр нь бас тэмцэлтэй. Яагаад гэвэл тэнд далдуур бас юмнууд яваад байгаа байхгүй юу. Тэгээд үнэтэй зүйл нь хог дээр хаягдаад байдаг.

Тэгэхээр энэ дээр ил тод болгох нь өөрөө энэ далд эдийн засгаа алга болгоход их чухал үүрэг гүйцэтгэж байгаа юм.

Тэгэхээр мөн ялгаагүй энэ дээр эдийн засгийг ил болгох чиглэлийн ажлууд энэ далд эдийн засгийг алга болгоход чухал үүрэг нэмэртэй.

Мөн авлигатай тэмцэж байгаа төр, засгийн бодлого үндсэндээ үр дүнгүүдээ өгч байгаа гэж үзэж байгаа. Ийм учраас ч бид эдийн засгийн өсөлтийг **7** гэж авч үзэж байгаа.

Дотоодын нийт бүтээгдэхүүнийхээ хэмжээг **74 их наяд төгрөг** гэж авч үзэж байгаа. Зарим хүмүүс 74 хэт өөдрөг гэсэн аудитын дүгнэлт үзэж байна.

Валютын сан үндсэндээ 72.5 их наяд төгрөг болно гэж байгаа шүү дээ. Хамгийн пессимист байдлаар үнэлгээ хийж явдаг. Бид 74-өөр оруулж ирж байгаа.

Өөдрөг биш. Зориод хариуцсан хариуцсан ажлаа бүгдээрээ зөв хийгээд арчаатайхан шиг, бага попроод, ажил дээрээ гол гол юмаа хийгээд явчих юм бол 74 байтугай үр дүнг бид гаргах боломжтой гэж үзэж байгаа.

Тэгэхээр экспортынхоо зах зээлүүдийг нэмэх, үйлдвэрлэл эрхлэхэд боломжуудыг нь бий болгоод явахад өсөлтүүдээ гаргачих боломжтой гэж үзэж байгаа.

Харин Б.Баттөмөр гишүүний хэлж байгаа тэр инфляцын дарамт үнэхээр бид маш сайн бодох ёстой. Хүн болгоны амьдралд нөлөөлдөг.

Тийм учраас Монголбанк дээрээс, Төв банк дээрээс мөнгө хэвлэх ямар нэгэн тийм яриа огтхон ч байж болохгүй. Одоо мөнгөний бодлогын хэлэлцүүлгийн үеэр бас тийм зарим саналууд гаргаад байна шүү дээ.

Мөнгө хэвлэж юм хийх тухай саналуудыг гаргачихсан. Түүгээрээ санал хураалгах гээд гүйгээд байдаг. Ийм зүйл байхгүйгээр, мөнгө огт хэвлэхгүйгээр, тэгээд дээр нь тээвэр ложистикийнхоо зүйлүүдийг хийгээд, зах зээлээ зөв нээгээд, өрсөлдөөнийг нь хангаад тийм далд хаасан, боосон зүйл багатайхан шиг явах юм бол инфляцыг зориод байгаа 8.5 хувь руугаа оруулчих боломжтой гэж үзэж байгаа.

Хамгийн гол нь бид ханшаа алдаж болохгүй. Нөөцөө сайн бүрдүүлээд тэгээд хичээгээд ажил явахад би болно оо л гэж үзэж байгаа.

Зүгээр яах вэ урсгалаар нь явуулаад байвал юу гэдэг юм.../минут дуусав/

Ц.Цэрэнпунцаг: Нэмж ажлын хэсгээс 4 номер. Тэр тодорхой бяслагийн үйлдвэр гээд ямар төслүүд явагдаад байгаа юм. Тодорхой хариулаарай. 4 номерыг нэе.

М.Ганхүлэг: Ажлын хэсгийн гишүүд Та бүхэндээ энэ өдрийн мэндийг хүргэе.

Хүнс, хөдөө аж ахуйн дэд сайд М.Ганхүлэг байна.

2024 оны улсын төсөвт Сангийн яам руу **76 төсөл, арга хэмжээний нийтдээ 394.0 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын саналыг** Хүнс, хөдөө аж ахуйн яамнаас илгээсэн.

Үүнээс ойролцоогоор **94.0 тэрбум** төгрөгийн санхүүжилтийг олгохоор төсвийн төсөлд орж ирсэн байгаа.

Шинэ болон шилжих хөрөнгө оруулалттай холбогдолтой асуултыг асууж байна.

Бяслагийн үйлдвэрийн тоног төхөөрөмжийг Хөвсгөл аймгийн Мөрөн, Чандмань-Өндөр сумдад хийе гэдэг санал орж ирсэн. **1.4 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй.** 2024 онд **700.0 сая** төгрөгийг нь тусгасан байгаа.

Энэ удаагийн төсвийн бас нэг гол онцлог нь Монгол Улсын Ерөнхий сайд бүх аймгуудаар явж ажилласан. Бүх аймгуудаар явж ажиллахдаа иргэдийн уулзалтыг зохион байгуулаад, тэгээд иргэдийн уулзалт дээр бүх шийдүүлэхийг хүсэж байгаа асуудлуудыг нь эрэмбэлүүлсэн.

Энэ дээр хамгийн дээгүүр орж ирсэн төсөл, арга хэмжээг олон нийтийн өмнө хийж хэрэгжүүлнэ гэдэг амлалтын дагуу энэ төсөвт орж ирсэн байгаа юм.

Бусад шилжих хөрөнгө дээр Дорноговь аймагт хийгдэхээр байгаа ажилтай холбогдолтой санал орж ирсэн.

Ноос хяргах байгууламж, тоног төхөөрөмж, Дундговь аймгийн Хулд сумд байгаа. Энэ нь шилжих хөрөнгө байдлаар орж ирж байгаа юм.

Энэ жилийн хувьд **279.8 сая** төгрөгийг үндсэндээ гаргахаар төсөвт орж ирсэн. Үүнд барилга байгууламж, ноос хяргах жишиг төв болгон ажиллуулахаар тооцсон байгаа.

Ноостой холбогдолтой энэ салбарыг хөгжүүлэхтэй холбогдолтой бас нэлээн үлгэр жишээ хийгдэж байгаа

“Шинэ хөдөө” төслийн хүрээнд хийгдэж байгаа арга хэмжээнүүдийн маань нэг байгаа юм.

Ц.Цэрэнпунцаг: Бүтээмжийн талаар асуулт асуусан. Сангийн яамнаас хэн байна? Ажлын хэсгийн 3 номерын микрофоныг нээе.

С.Мөнхчимэг: Б.Баттөмөр гишүүний асуултад хариулья.

Эдийн засгийн өсөлтийн хэдэн хувийг нь **“бүтээмжийн өсөлт”** эзэлж байгаа вэ гэсэн асуулт асуусан байна. Эдийн засгийн хөгжлийн яам энэ дээр тодорхой хариулт өгөх байх аа.

Ц.Цэрэнпунцаг: Ч.Хүрэлбаатар сайдын микрофоныг нээе.

Ч.Хүрэлбаатар: Орчин үеийн эдийн засгийн өсөлт юунаас гардаг болчихов гээд үзэхээр ер нь улс орны эдийн засгийн хөгжил дандаа тийм их өрсөлдөөнөөс, ил тод байж гардаг зүйлүүд байгаа.

Үүн дээрээ нэмэгдээд бид зүгээр яах вэ, тооны өсөлтүүд байгаа. Экспортоор хэмжигдэж байгаа. Урагшаа хилээр гарч байгаа экспортын хэмжээ эрс нэмэгдэж байгаа. Малын өсөлт ч байдаг юм уу. Тийм ээ.

Уг нь фермерийн аж ахуй нь илүү хүчтэй хөгжиж, хөдөө аж ахуйн салбараас олдог орлого нь илүү нэмэгдэж байж түүн дээр бүтээмжийн өсөлтүүд гардаг.

Бид яг одоо бүтээмжийн өсөлт гээд яг нарийн тооцоо, судалгаа хийгдээгүй. Энэ бүтээмжийн судалгаа хийхийн тулд яах аргагүй энэ дээр **“эконометрик судалгаа”** хийж байж энэ

дээр яг төчнөөн нь бүтээмжийн өсөлтөөр гарч ирсэн буюу гэдгийг тооцож гаргана.

Энэ нь өөрөө **“Солоугийн загвар”** [Solow Growth Model] /Robert Merton Solow/ гэдэг.

Нэлээд сайн цаг хугацааны мэдээлэлтэй байж, түүн дээр үндэслэж гаргадаг.

Тэгээд яг энэ тооцоон дээрээ бид өсөлтийн тийм загварыг тооцож оруулаагүй байгаа гэдгийг би хэлье.

Нарийн тоог тооцож байж хэлье. Яг цэвэр өмнөх өсөлт дээрээ үндэслэж гарч ирж байгаа салбаруудаа, мөн манай томоохон тэргүүлэх аж ахуйн нэгжүүд дээр үйл ажиллагаанд нь орж байгаа өөрчлөлт дээрээ үндэслэж гаргаж ирсэн тооцоо байгаа.

Ер нь Монгол Улсын эдийн засгийн өсөлтийн хэчнээн хувь нь **“бүтээмжтэй холбоотой вэ”**, хэчнээн нь **“техник, технологитой холбоотой вэ”**, хичнээн нь **“хүний хүчин зүйлээс холбоотой вэ”** гээд энэ бүгдийг нарийвчилж хийх шаардлагатай болов уу гэж байгаа.

Нэлээд том ажил хийгдэх ёстой байх аа, энэ дээр.

Ц.Цэрэнпунцаг: Б.Баттөмөр гишүүн тодруулж асууя.

Б.Баттөмөр: Ер нь төсөв, төлөвлөгөө хийхэд хамгийн гол асуудал **“бүтээмжийн өсөлт”** шүү дээ.

Бүтээмжийг өсгөж байж цалин нэмнэ. Тэгж байж л үр дүн гарах ёстой л доо. Судалгаа хийх нь зөв байх.

Сая тэр уул уурхайн биржийн талаар Ч.Хүрэлбаатар сайд ярьчихлаа. Манай Байнгын хороо үүнийг хийсэн.

Яах вэ, Засгийн газраар санал оруулсан. Хийсэн хүмүүсийн нэг нь би сууж байна.

Анхны цан цохиход **60** доллароор худалдаж байсан нүүрсийг **187** доллароор л худалдаж байлаа. Далд эдийн засгийг ил болгосон.

Харамсалтай нь энэ хуульд юу гэхээр Хятадын компанитай байгуулсан жилд 20 сая тонн нүүрсийг “**биржийн бус арилжаагаар худалдана**” гэж байгаа юм. Үүнийг л дагасан хулгай бас гараад ирнэ шүү дээ. Ч.Хүрэлбаатар сайд аа.

Тийм учраас үүнийг тэр биржийн үнэтэйгээ нийцүүлж худалдана гэсэн өөрчлөлтүүдийг хийх нь зүйтэй байх. Тэгэхгүй бол болохгүй.

Ц.Цэрэнпунцаг: Санал хэлчэв үү? Та. Ч.Хүрэлбаатар сайд хариулна.

Ч.Хүрэлбаатар: Биржийн хуулийн үйлчлэлийг бууруулах ямар ч алхам байж болохгүй шүү гэж Б.Баттөмөр гишүүний хэлж байгаатай би 200 хувь санал нэг байна.

Яг Гашуунсухайт, Ганцмодын чиглэлийн тэр холболтын төмөр замыг хийхэд түүнтэй холбоотой урт хугацааны гэрээ хийгдэх тухай асуудлууд байгаа юм.

Тэгэхээр тэр бүх зүйлүүдийг нь хасаад зөвхөн яг нэр устайг нь зааж байгаад тэрийг нь нэгдүгээрт зөвшөөрөл өгчихвөл тэр холболтын төмөр зам нь явах юм билээ.

Хоёрдугаарт, биржийн үнэ гэж. Яаж зохицуулах ёстой вэ гэж.

Би бол ерөөсөө маш энгийн л байр суурьтай байгаа. 5 жилийн хугацаанд гэрээгээр нийлүүлээ гэж бодоход зүгээр л биржээр зарагдаж байгаа үнүүдийнхээ дунджаар гэрээгээ хийчхэд л болно.

Тэгэхээр түүн дотроо “**биржийн үнүүдийн дунджаар**” гэдгийг хийхгүй бол юу гэдэг юм, янз бүрийн юм тооцно, энэ тэр гэдэг юм л орж ирэх юм бол түрүүний тэр буруу зүйл л явагдана.

Тэгэхээр зүгээр “**биржийн цаг хугацаанд зарагдсан үнүүдийн дунджаар**” гээд л.../минут дуусав/

Ц.Цэрэнпунцаг: Б.Баттөмөр гишүүний асуусан асуулттай холбогдуулаад зүгээр нэг санаа хэлчихье.

Ер нь дараагийн жил ингээд бид дахиад л энэ төсвөө оруулж ирээд л ярилцана, хэлэлцэнэ.

Ер нь Эдийн засгийн хөгжлийн яам шинээр байгуулагдсан. Одоо ингээд бас ажил нь жигдэрч байгаа.

Тийм учраас дараагийн жил яг энэ бүтээмжтэй холбоотой өсөлтийн талаар олон гишүүд асууж ярих байх.

Тийм учраас олон талаас нь мэдээлэл авч, нэлээн нарийн судалгаа хийгээд дараа жил өсөлтийн хэд нь бүтээмжтэй уялдаж холбогдож байгааг нэг тодорхойлоод. Байг гэхэд гаалиар орж ирж байгаа техник, тоног төхөөрөмж дээрээ үндэслээд ямар технологи илүү сайн байна, ажиллах хүчнийхээ ажиллах чадвар, бүтээмжийг нэмэгдүүлэхэд ямар чиглэлийн хөрөнгө оруулалт хийгдэж байна, өсөлтийг яаж харж байна. Энэ тал

дээрээ нэлээн нарийн тодорхой ярьдаг болох байх гэж байна.

Тийм учраас Эдийн засгийн хөгжлийн яам цаашдаа энэ тал дээр мэргэжилтэн, нөөцөө бэлтгэж судалгаан дээрээ жоохон анхаарал тавьж ажиллавал зүгээр байна гэж бодож байна.

Ингээд Ш.Адьяшаа гишүүн асуултаа асууя. Гишүүний микрофоныг нээе дээ.

Ш.Адьяшаа: Баярлалаа.

2024 оны төсвийн асуудал, улсын орлого, зарлагын асуудлыг өнөөдөр Улсын Их Хурал хэлэлцэж байгаа.

Уул уурхайн сайд байгаа юу, байхгүй юу? Уул уурхайн сайдаас дараа нь асуучихъя.

Хүнс, хөдөө аж ахуйн сайдын ажлын албанаас л асууна даа. Тийм ээ. Бас гадаадад байгаа гэсэн.

Хүнс, хөдөө аж ахуйн асуудал өнөөдөр Монгол Улсын эдийн засгийн хамгийн чухал асуудал.

Энд хөрөнгө оруулалт, ялангуяа хүн ардынхаа хүнсний хангамжийг сайжруулах, Монгол Улсад хүнсний бүтээгдэхүүнээ экспортод гаргах бодлогын талаар тодорхой зүйлийг тодруулах шаардлагатай байна.

Сүүлийн жилд мах, махан бүтээгдэхүүнийг экспортлох талаар дорвитой өөрчлөлт хийгдээгүй байгаа. Эрээнээр нэг мах гаргадаг. Энэ нь ер нь хэр үр дүнтэй байна аа?

Түүнчлэн Эрээн боомтоор амьд мал гаргаад байгаа. Үүнийг зайлшгүй бодлогын хэмжээнд дэмжих

шаардлагатай байгаа юм. Энэ амьдаар мал гаргаж байгаа асуудлуудыг зөвхөн Эрээнээр биш бусад боомтуудаар гаргахад Хүнс, хөдөө аж ахуйн яам ямар дэмжлэг үзүүлж байна аа?

Бид өнөөдөр түүхий махаа гаргаж чадахгүй байгаа. Гэтэл өнөөдөр Замын-Үүд боомтоор Хятадын талаас амьд малыг авах шалгуур нөхцөл тавиад тодорхой хэмжээний малыг экспортолж байна. Үүнийг бодлогын хэмжээнд цаашид үргэлжлүүлж, бусад боомтуудаар, баруун аймгуудын боомтууд, энэ говийн аймгийн боомтуудаар мах гаргахад ямар бодлого барьж байна гэдэг талаар нэг асуулт асууя.

Нөгөө талаасаа Хүнс, хөдөө аж ахуйн сайдын багцад жил бүхэн л явагддаг. Хүнсний хангамжийг сайжруулна, гурилын үнийг буулгана, махны үнийг буулгана гээд өчнөөн олон төрлийн хөнгөлөлттэй зээлийг тавьдаг.

Түүрүүн нэг төсвийн танилцуулга дээр ярьж байсан. Ерөнхийлөгчийн хүнсний хангамжийг бид сайжруулах гэж ийм юм тавьж байгаа гэж. Ерөнхийлөгчийн бодлого чинь өөр. Энэ үр дүнгээ өгдөггүй.

Өнөө жил энэ улсын төсөв дээр хэдэн тэрбум төгрөг тавьсан юм? Гурилын үнийг буулгана гэж тавьдаг. Та бүхэн. Будааны үнийг буулгана гэж тавьдаг. Махны үнийг буулгана гэж хөнгөлөлттэй зээл тавьдаг. Тэр нь ард түмэнд ямар ч өгөөж байдаггүй. Хэдхэн тооны том компаниуд хувааж авдаг ийм авлигын сүлжээ байгаа гэж би харж байгаа.

Энд ямар дүгнэлттэй байна? Энэ хэр үр дүнгээ өгсөн бэ?

Одоо гурилын үнэ чинь, махны үнэ чинь тэнгэрт хадлаа шүү дээ. Тэгтэл энэ дээр зээлийн бодлогоор явах юм уу, зах зээлийн жишгээрээ явах юм уу? Яам энд ямар бодлого баримталж байна. Энэ талаар нэг хариулт авъя.

Ц.Цэрэнпунцаг: Ч.Хүрэлбаатар сайд хариулъя.

Ч.Хүрэлбаатар: Ш.Адъяаа гишүүний хоёр асуултад хариулъя.

Эхнийх нь амьд мал гаргах тухай асуудал.

Амьд мал гаргана гэдэг нь бид нөгөө нүүрс, эд нар ямар нэгэн боловсруулалтгүй шууд гаргаж байгаатай л адилхан зүйл шүү.

Тийм учраас яах вэ, одоохондоо ингээд хэсэг хугацаанд амьд мал гаргаж байгаа байх.

Ер нь цаашдаа бид малаа эрүүлжүүлээд, малаа Монголдоо нядлаад, бүрэн хаягдалгүй байх тал дээрээ арьс ширийг нь, ноолуурыг нь, махыг нь. Өөр юу байдаг юм. Тэр нарийн гэдэс, дотор бүгдийг нь ашигладаг. Үүнийгээ бүгдийг нь үнэ хүргэж зардаг ийм л болгохын төлөө бид хичээж чармайж явах ёстой.

Өөрөөр хэлбэл боловсруулалтын шатуудыг бид нэмэх тусмаа л бидэнд эргээд Монголд үлдэх нэмүү өртөг нь илүү байгаа.

Тийм учраас Засгийн газар хөрш орнуудтайгаа гэрээ хэлцлүүд нэлээн сайн хийж байна.

Монголоос гарах хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүнүүдийн зах зээлийг нэмэгдүүлэх чиглэлээр бас нэлээд ажиллаж байна. Тэгээд бидний хувьд

мэдээж Монгол талдаа малаа эрүүлжүүлэх, тэр шаардагдаж байгаа эрүүл ахуйн олон шаардлагыг хангах зэрэг ийм бодлогыг хэрэгжүүлэхэд явах нь зөв өө гэж, ийм юм бодож байгаа гэдгийг би нэгдүгээрт нь хэлье.

Өөрөөр хэлбэл малыг эндээ Монголдоо нядлаад бүрэн боловсруулалт хийгээд гаргадаг тогтолцоо руу шилжих нь Монголдоо ашигтай шүү гэдгийг би нэгдүгээрт хэлье.

Хоёрдугаарт, тэр төрөл бүрийн дотаци өгөөд байдаг. Энэ ингээд янз бүрийн схемд орчихсон гэж. Би тантай 100 хувийн санал нэг байна. Дотациар олгож байгаа тэр тогтолцоо нь өөрөө асуудалтай. Орц дээрээ биш үр дүн гарахаар нь өгдөг дотациуд нэлээдгүй орнуудад бий.

Тийм учраас Монгол Улсын хөдөө аж ахуйн салбарын бодлогыг бид өөр нүдээр авч үзэхгүй бол үр дүнгээ өгөхгүй байгаа бодлогууд хэрэгжээд яваад байгаа гэж таны хэлж байгаа шүүмжлэлтэй санал нэг байна. Энэ дээр ажиллаж байгаа.

Ц.Цэрэнпунцаг: Ш.Адъяаа гишүүн нэмээд тодруулж асууна. Ш.Адъяаа гишүүний микрофоныг нээ.

Ш.Адъяаа: Үүнийг би яагаад ингэж мал амьдаар гаргах тухай ярьсан юм гэхээр 2019 оноос хойш судалгаагаар нэг ч килограмм түүхий мах бид экспортод гаргаагүй байгаа.

Тэгээд одоо өнөөдөр энэ үйлдвэрээ бариагүй байгаа. Цаашлаад хэдийд энэ гадаадын хорио цээрийн дэглэмийг бид давах юм уу, давахгүй юм уу гэдэг асуудал чинь байгаа юм.

Ийм учраас малчдын орлогыг нэмэгдүүлэх талаар малыг амьдаар гаргах асуудлыг бүх аймгуудаар тодорхой хэмжээгээр гаргаж байж л бид өнөөдөр малчдынхаа малыг эргэлтэд оруулна гэдэг бодлогын үүднээс ярьж ж байгаа.

Дээр нь ээмэгжүүлнэ гээд хүмүүс их шүүмжлээд байгаа юм. Энэ ээмэгжүүлнэ гэдэг малаа бүртгэлжүүлэхгүйгээр, бид эрүүл бүсийг байгуулахгүйгээр бид нэг ч үр дүн гарахгүй.

Ийм учраас тэр малыг бүртгэлжүүлэх асуудал дээр ер нь хэдий хэмжээний хөрөнгө мөнгө тавьсан бэ? Энэ талаар.../минут дуусав/

Ц.Цэрэнпунцаг: Хүнс, хөдөө аж ахуйн яам хариулах уу? 4 номер. Ажлын хэсгийн 4 номер хариулья.

М.Ганхүлэг: Ш.Адьяшаа гишүүний асуултад хариулья.

Мах, махан бүтээгдэхүүний экспорттой холбогдолтой би бас тодруулаад мэдээлэл өгчихье.

Хүнс, хөдөө аж ахуйн яамнаас бүх төрлийн махан дээр квотгүй олгох ийм шийдвэрийг өнгөрсөн онд гаргасан. Үүнтэй холбогдолтойгоор 57 мянган тонн мах экспортод гараад байна.

Амьд малын тоо 70 мянга орчим болсон байгаа. Нэг аж ахуйн нэгж үржлийн бус бог малыг экспорт гаргаж байгаа. Богино хугацаанд авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ байгаа. Цаашдаа түүхий эд бэлтгэх, эцсийн бүтээгдэхүүн болж гаргах тал дээр Хүнс, хөдөө аж ахуйн яам анхаарч ажиллахаар байгаа.

Гол суурь асуудал бол мал эрүүлжүүлэхтэй холбогдолтой асуудал байгаа юм.

Ээмэгжүүлэлт гэдэг энэ асуудлыг бас их тийм зөв нэр томъёогоор ярих хэрэгтэй байгаа юм. Энэ мал бүртгэлжүүлж таних. Тэгээд яг вакцин туулга, малд ямар үйлчилгээ юмнуудыг үзүүлсэн бэ гэдгийг нотлох гээд байгаа гол ийм суурь асуудал байгаа. Мал эмнэлгийн үйлчилгээ болон үржил селекцийн ажлыг баталгаажуулж нэгж малаар нь олон нийтэд болон олон улсад бид бүхэн ойлгуулах шаардлагатай байдаг.

Тэгээд үүнтэй холбогдолтойгоор 500 сая төгрөгийн төсвийг 2024 онд оруулсан байгаа. Энэ нь малд үзлэг, ангилалт хийх, ялган тэмдэглэж бүртгэлжүүлэх, удам зүйн үнэлгээ хийх замаар малын ашиг шимийн үзүүлэлтийг тодорхойлох мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх гээд бүр нэлээн олон асуудлуудыг нэгтгээд 500 сая төгрөгийг оруулсан.

Цаашдаа мал эмнэлгийн нэгдсэн систем болон бусад чиглэл дээрээ илүү анхаарал хандуулж, таны хэлж байгаа шаардлагыг зайлшгүй хийх шаардлагатай байгаа юм.

Тэгээд Хүнс, хөдөө аж ахуйн яамнаас өнгөрсөн жилийн хугацаанд малын түүхий эдийг илүү сайжруулах, түүхийгээр нь ч болтугай эдийн засгийн эргэлтэд оруулах энэ асуудлууд дээр нэлээн анхаарал хандуулж ажилласан.

Арьс ширний квотын тухай сая Ч.Хүрэлбаатар сайд танилцууллаа. Ноолуур дээр ч гэсэн үнэ унахгүй байх асуудлууд дээр нэлээн анхаарч ажилласан.

Тэгээд ямартай ч 2023 оны суурь үзүүлэлтүүд бас нэлээн эерэг ийм үр дүнгүүд гарч байгаа.

Улсын Их Хурлын 36 дугаар тогтоолтой холбогдолтой арилжааны банкнуудтай хамтарсан зээлийг та түрүүн асуусан. 10 арилжааны банкаараа дамжуулаад энэхүү зээлийг үргэлжлүүлж олгох асуудлуудыг энэ жил оруулсан. 125 тэрбум төгрөгийн санхүүжилтийг энэ дээр оруулж ирсэн байгаа.

Ингэснээрээ төр хувийн хэвшлийн өмнө орж ажиллах энэ асуудлыг бие дааж аж ажиллах, хувийн хэвشلүүд өөрсдөө зээлээ бага хүүтэйгээр аваад ингээд газар тариалан, хүнсний үйлдвэрлэл, мал аж ахуйн чиглэлээрээ бизнесээ өргөжүүлээд явах энэ суурь асуудлаа шийдэхэд нь бодлогын дэмжлэг болгож оруулж байгаа ийм асуудал байгаа юм.

Ц.Цэрэнпунцаг: Ш.Адьяшаа гишүүн Та хариулт хангалтгүй гэж үзэж байвал 1 минут танд өгье. Нэмж асууна. Ш.Адьяшаа гишүүний микрофоныг нээе.

Ш.Адьяшаа: Би тэр мал ээмэгжүүлнэ гэдэг буруу ойлголтоор та нар яриад байх шиг байгаа юм. Үүнийг маш их дэмжиж байгаа хүн байгаа юм.

Бид малаа бүртгэлжүүлж бүртгэлийн системийг бий болгохгүйгээр өнөөдөр тэр дэлхийн мал эмнэлгийн байгууллагаас тавьсан шаардлагыг биелүүлэхгүйгээр бид өнөөдөр малаа гадаадын зах зээлд борлуулна гэсэн ойлголт ерөөсөө байхгүй.

Энэ дээр бүртгэлжүүлэх, энэ дээр 500 сая төгрөг тавина гэдэг чинь маш хангалтгүй л асуудал шиг санагдаж байна.

Нөгөө талаараа тэр зээл өгөөд ямар үр дүн гарсан юм бэ гэж би асуусан. Гурилын үнэ чинь яагаад өсөөд байгаа юм? Арилжааны банкаар өгөөд байна л гээд байна. Махны үнэ чинь яагаад өсөөд байгаа юм? Үр дүн гарахгүй байна шүү дээ.

Энд хэчнээн компани авсан юм? Тэр компаниудынх нь нэрийг нь бүгдийг нь Улсын Их Хурлын чуулган дээр хэлээд өгчих.

Гурилын үнийг буулгахад хаанахын хэдэн компани мөнгө авсан юм? Арилжааны банкаар авдаг юм байж.

Дээр нь гурилын үнийг, махны үнийг буулгахдаа яагаад буухгүй байгаа юм. Төр, хувийн хэвшил нь үнэхээр сайн ажиллаж байгаа юм бол. Энэ талаар нэмж тайлбар авъя.

Ц.Цэрэнпунцаг: Хариулья. Ажлын хэсгийн 4 номер.

М.Ганхүлэг: Үнэтэй холбогдолтой асуудал дээр Хүнс, хөдөө аж ахуйн яам болон төр, засгаас үнийг яг тодорхой хэмжээнд нөлөөлөх, тогтворжуулах ийм боломж байхгүй. Зах зээлийн зарчмынхаа дагуу үнэ тогтоод ажиллаад явж байгаа.

Түүнд тодорхой хэмжээнд дэмжлэг үзүүлэх алхмуудыг хийж хэрэгжүүлэх нь зайлшгүй байдаг.

Мах, гурилын үнэтэй холбогдолтой, гурилын үнэтэй холбогдолтой энэ жилийн ургацын байдал нэлээдгүй эерэг байдалтай гарч байгаа. Улаан буудайгаа бид бүхэн дотооддоо 100 хувь хангаж байгаа.

Сүүлийн жилүүдэд газар тариалангийн салбарт нэлээдгүй

хэмжээнд, саяын ярьсан энэ арилжааны бага хүүтэй зээлүүдийг олгосны үр дүнд ямар ч байсан бид гаднаас будаа гуйхааргүй болж байгаа. Өөрсдөө дотооддоо 100 хувь будаагаа үйлдвэрлээд явах боломжтой болж байгаа.

Тэгээд үнэд нөлөөлж байгаа хэд хэдэн орцууд байгаа юм. Тээврийн асуудал, түлшний асуудал, ажиллах хүчний асуудал, бордоо гээд олон бас хүчин зүйлүүд байгаа. Үүнтэй хамааралтайгаар үнэ тогтдог.

Тэгээд энэ үүднээс тодорхой хэмжээнд хувийн хэвشلүүд маань гурилын үнэ дээрээ бас. Үүнийг тогтвортой хэмжээнд буулгаж барих энэ чиглэл дээр ямар нэгэн байдлаар 2024 онд үнэ тогтворжуулах зорилгоор төсөв оруулаагүй.

Махны асуудал дээр ч гэсэн.

Ц.Цэрэнпунцаг: Техникийн саатал гарсан учраас минут чинь өнгөрөөж явчихлаа шүү. 1 минутад хариулах ёстой. Хугацаа чинь дуусчихлаа. Ингээд дуусгачих.

Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Ингээд санал хураалтаа явуулж эхэлье.

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2024

оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? Алга байна.

Ингээд төсвийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг хийсэн талаар Эдийн засгийн байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Дамдинсүрэнгийн Өнөрболор Төсвийн байнгын хорооны хуралдаанд танилцуулна.

Монгол Улсын 2024 оны төсвийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг хэлэлцэж дууслаа. /алх цохив/

Ингээд дараагийн асуудалдаа орёё.

Ажлын хэсгийнхэн байж байна шүү. Одоо дагасан хуулиуд орж ирнэ шүү дээ. Техникийн саатал гарчхаад байна.

Тэгээд өнөөдрийн Байнгын хорооны хуралдаанаа 15 минутын хугацаатай түр завсарлага авахгүй болохгүй болчхоод байна.

Өнөөдрийн Эдийн засгийн байнгын хорооны хуралдаан техникийн саатал гарсантай холбоотойгоор ирц бүрдэх боломжгүй болсон учраас ингээд өнөөдрийн хуралдааныг хойшлуулъя.

Хуралдаан 58 минут үргэлжилж, 15 цаг 53 минутад өндөрлөв.

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ**

Ц.АЛТАН-ОД